



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 1/66

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн аравдугаар хуралдааны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтанд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.5 дахь заалт Хилийн уулзалтын байр засварлах /ХЦ-ийн 0130 дугаар анги/ 17,0 сая төгрөгийн, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 1.1 дахь заалт Баян модны заставын худаг гаргах /ХЦ-ийн 0130-р анги/ 25,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулах эрхийг Хилийн цэргийн 0130 дугаар ангийн дарга /О.Азхүү/-д шилжүүлсүгэй.


2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 2 дугаар сарын 20-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 3 дугаар сарын 25-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлтэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг арга хэмжээ авч, үр дүнг 8 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг Хилийн цэргийн 0130 дугаар ангийн дарга /О.Азхүү/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Гончигсүрэн/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/ нарт хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ